

ТОДРУУЛАГА

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл (Ховд, Мөст сум)” ЭМЯ/20240101023 дугаартай тендэрт “Турлиахт” ХХК-иас 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 24/64 тоот тодруулга авах тухай албан бичгийн хариу:

-ТШЗ.19.1 Техникийн чадавх болон туршлагын шаардлагад Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 60 хувиас багагүй үнийн дүнтэй Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр ажилласан байх гэж заасан. Иймд танай ирүүлсэн албан бичигт 2020-2021 онуудад хэрэгжиж дуусахаар 2020 онд гэрээ байгуулсан ажил нь цахим системд 2020 онд хэрэгжүүлсэн ажилд орох тул ижил төстэй ажлын туршлагад тооцогдохгүй болно.

- Хэрэв хэрэгжүүлэхээр эрх авсан дуусаагүй ажил нь 90 хувиас доошгүй гүйцэтгэлтэй байгаа тохиолдолд ижил төстэй ажилд тооцох эсэх. Энэ тухайд ТШЗ.19.2.3-д зааснаар Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ: Ажил гүйцэтгэсэн гэрээ, техникийн болон улсын комиссын акт, захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ гэж заасан тул дуусаагүй ажил нь ижил төстэй ажлын туршлагад тооцогдохгүй болно.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр